



БАЯНХОНГОР АЙМАГ  
ЖАРГАЛАНТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 04 сарын 05 өдөр

Дугаар А/41

Эмээлтологой

「Хязгаарлалтын дэглэмд шилжих тухай」

Монгол Улсын гамшгаас хамгаалах тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.22, 4.1.23, 4.1.17, 32 дугаар зүйлийн 32.1.9, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Тус сумын Нам толгой 1 дүгээр багийн нутаг Их дөт, Элстийн ам зэрэг газруудад гарсан мал, амьтны гоц халдварт шүлхий өвчний халдварыг таслан зогсоох, голомтыг устгах, халдвар тархахаас урьдчилан сэргийлэх зорилгоор “Хорио цээрийн дэглэм”-ийг 28 хоногийн хугацаатай тогтоож, халдварын голомтод байгаа мал сүрэгт үзлэг тандалт, халдваргүйжүүлэлтийг тогтмол хийж ажилласнаар өвчний дэгдэлт буурч дахин голомт нэмэгдээгүй тул 2022 оны 04 дүгээр сарын 05-ны өдрөөс эхлэн 14 хоногийн хугацаанд хязгаарлалтын дэглэмд шилжүүлсүгэй.

2.Мал, амьтны гоц халдварт шүлхий өвчний үед мөрдөгдөж байгаа хязгаарлалтын дэглэмийг баримтлан, хяналтын постонд гарч байгаа албан хаагчдийг удирдлага арга зүйгээр хангаж, хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Д.Ганзориг)-д, шүлхий өвчний хариу арга хэмжээ, хязгаарлалтын дэглэмийг хэрэгжүүлэх, халдварын шинэ голомт үүсэхээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч ажиллахыг “Давхарын нуруу” мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн малын их эмч (Б.Болормаа), багийн Засаг дарга (Ч.Цэдэвсүрэн)-д тус тус үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Б.Өнөрбаяр)-т үүрэг болгосугай

ДАРГА



Д.МӨНХЖАРГАЛ